

“МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН ХОСОЛСОН ЗАГВАР АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	Төслийн нэр	“Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл
2	Санхүүжүүлэгч байгууллага	Япон улсын JICA байгууллага
4	Төсөл хэрэгжүүлж буй хугацаа	2006-2009 он
5	Төслийн зорилго	Хөдөө орон нутгийн иргэдийн оролцоотойгоор тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, эрчимжсэн, хосолсон аж ахуйн загварыг хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.
6	Төслийн зорилтууд	<p>1.Төсөлд хамрагдсан бүс нутагт, загвар болохуйц МАА болон Газар тариалангийн чиглэлээр хосолсон үйл ажиллагаа явуулах чадвартай аж ахуйнууд сонгогдож үйл ажиллагааны чиглэл нь тодорхой болно.</p> <p>2.Сонгогдсон аж ахуйн МАА, газар тариалангийн эрчимжсэн, хосолсон аж ахуй эрхлэх менежментийн арга зүй сайжирна.</p> <p>3.Сонгогдсон аж ахуй нь ХАА-н салбарын болон зах зээлийн мэдээ мэдээллийг авах бололцоотой болно.</p> <p>4.Сонгогдсон аж ахуйнууд нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, нийлүүлэлт, худалдан авалтыг хамтран хэрэгжүүлснээр ашиг орлогоо нэмэгдүүлж менежментийн үйл ажиллагаагаа сайжруулна.</p> <p>5.Сонгогдсон аж ахуйн жишээг нэгтгэж бусад бүс нутагт танилцуулна.</p>
8	Санхүүгийн талаар:	<p>Тус төсөл нийт 2,0 сая. ам долларын төсөвтэйгээс 1,8 сая.ам олларыг зарцуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Сургалтад-351,0 мян.\$ -үйл ажиллагааны зардалд-416,0 мян.\$ -тоног төхөөрөмжийн зардалд-465,0 мян.\$ -урт болон богино хугацааны мэргэжилтний зардалд-457,0 мян.\$ -3 удаа үнэлгээ хийхэд-95,0 мян.\$ -оффисын хэрэгцээнд тоног төхөөрөмж авахад-12,0 мян.\$ -тайлан хэвлүүлэхэд-6,0 мян.\$ зарцуулсан байна.
9	Төслийн хэрэгжилт	88.2% буюу “ Хангалттай “ гэсэн үнэлгээг өгч байна.
10	Үр дүн 1. Төсөл хэрэгжих газарт ГТ-МАА хосолсон загвар аж ахуйд нэр дэвшигч аж ахуйн нэгжийг сонгож, төслийн үйл ажиллагааг шийдэх.	<p>Булган аймгийн Дашинчилэн, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумын 7-ААН, Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор сумын 8-ААН, Сэлэнгэ аймгийн Мандал, Зүүнбүрэн, Баянгол сумдын 9-ААН-үүд буюу нийт 24-ААН төсөлд сонгогджээ.Сонгогдсон аж ахуйн МАА-ГТ, ГТ-Зөгий гэсэн чиглэлээр хосолсон аж ахуй эрхэлж байна.Өнгөрсөн оны1 сард болсон явцын үнэлгээний үеэр 24 ААН нь ГТ, МАА-н иж бүрэн загварын нэр дэвшигч бөгөөд төсөл дуусахад 1 сумд нэгээс доошгүй ААН байхаар сонгоно гэж Монгол, Япон тал тохиролцсон. Дээрх 24-ААН –үүд нь анхны семинар(2006 оны 12 сард)-аар аж ахуй нэгж тус бүр өөрсдийн хийх ажлууд, хүрэх зорилго, үнэлэх аргуудыг Төслийн Загварчлалын Матрицын дагуу нэгтгэн дүгнэж, төслийн үйл ажиллагааг шийдвэрлэсэн.</p> <p align="right">Хэрэгжилт 100,0%</p>

<p>Үр дүн 2. Тогтвортой, өндөр ашиг шимтэй техник нэвтрүүлэх гарын авлага бэлдэх.</p>	<p>Зөвлөхүүд ААН-үүдийн талаар мэдээлэл цуглуулж, судалгаа, шинжилгээндээ тулгуурлан газар тариалангийн менежментийн Газар тариалан-Саалийн үнээ, Газар тариалан-Махны үхэр, Газар тариалан-Гахай, Газар тариалан-Зөгийний аж ахуй гэсэн дөрвөн хэсгийг багтаасан “Техникийн гарын авлага” боловсруулсан. Уг гарын авлага дээр богино хугацааны мэргэжилтэн “Бизнес менежмент” гэсэн хэсгийг нэмж “Техник нэвтрүүлэх гарын авлага” болгож гаргасан. Гарын авлагыг бүх аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа ашигласан бөгөөд ач холбогдлыг нь өндрөөр үнэлсэн. Эдгээр ААН-үүд арга барилд суралцахын зэрэгцээ газар тариалан болон МАА-н материал, багаж хэрэгслийг хэрхэн хэрэглэхийг сурч авсан байна. Сонгогдсон ААН-дэд нийт 404,3 сая төгрөгийн материал, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт (Хүснэгт 1-ээс үзнэ үү) хийгдсэн. Төслийн хүрээнд: ХААНТ-ийн менежерүүд болон ААН-дэд чиглэсэн 17 сургалт Монголд, 4 сургалт нь гадаадад болсон. ХААНТ-ийн менежерүүд болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид бүх сургалтыг сайшааж байсны дотор ялангуяа, төсөл хэрэгжиж буй газартай танилцах аяллыг илүү их онцолж байсан. БНХАУ-ын ӨМӨЗО-нд “Туршлага солилцох сургалт”, Вьетнам улсад “Хоршооны туршлага солилцох сургалт”, Япон улсад “Бүтээгдэхүүний боловсруулалт, нийлүүлэлт”, “Нэвтрүүлэх технологийг бэхжүүлэх” сургалтууд хийсэн нь тухайн орны туршлагыг судлах, өөрийн аж ахуйд туршиж нэвтрүүлэхэд чухал алхам болжээ. Дотоодын танилцах аяллыг -2 удаа зохион байгуулсан нь аж ахуйн нэгжүүд харилцан туршлага солилцоход чухал нөлөөлжээ. Жнь: Булганы Өлзийхандын эрдэнэ шишээр хийсэн даршийг Сэлэнгийн “Баруун шагшаа” хоршоо аж ахуйдаа нэвтрүүлж ажиллаж байгаа гэх мэт. Гарын авлага ашигласнаар 1га-аас авах ургацын хэмжээ, үнээний сүүний гарц нэмэгдсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 95.0%</p>
<p>Үр дүн 3. Сонгогдсон аж ахуйн нэгжүүд газар тариалан, мал аж ахуй, зах зээлийн талаарх мэдээлэл авах.</p>	<p>Сонгогдсон ААН-үүд зах зээлийн мэдээ, мэдээллийг радио, телевиз, сонин, гар утас зэргийг ашиглаж авдаг боловч ихэнх мэдээллийг сумдын ХААНТ-ын менежерүүдээс, ХААНТөвөөс авч байна. Сүүлийн үед төсөлд хамрагдсан ААН-ээс гадна бусад иргэд, ААН-үүд тус төвөөр их үйлчлүүлж мэдээлэл авч байгаа нь ХААНТ болон менежерүүдийн үүрэг, ач холбогдлыг харуулж байгаа нэг үзүүлэлт юм. Мөн ХХААХҮЯ-ны МХШҮГ-аас шаардлагатай мэдээллийг товхимол болгон хүргэж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 80.0%</p>

	<p>Үр дүн 4 Аж ахуйн нэгжүүд боловсруулах, борлуулах, маркетингийн салбарт хамтарч ажиллах.</p>	<p>Сонгогдсон ААН-үүд өөрсдийн тарьсан ногоо, боловсруулсан бүтээгдэхүүнээ аймаг, сум, УБ-т зохион байгуулагддаг Намрын ногоон өдрүүдийн үзэсгэлэн худалдаанд хамтарч борлуулж байна. Сэлэнгэ аймгийн “Баруун шагшаа” хоршоо бусадтай хамтарч “Скай” худалдааны төв дээр гэрээгээр борлуулдаг. Булган аймгийн Дашинчилэн сумын “Буудай” ӨАА нь “Үдийн цай” хөтөлбөрт боловсруулсан бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. Ийм маягаар аж ахуйн нэгжүүд нь аль хэдийн хоорондоо хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд үүнээс үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалтын мэдээлэл, арга барил солилцсон олон сайн үр дагавар гарч болох юм. ААН-үүд хоорондоо хамтран ажиллаж байгаа боловч, энэ талаар тайландаа тусгагддаггүйгээс жишээ татах баримт хомс байна. Үүний дагуу төслийн баг хуралдаж жишээг олон болгож, “Технологи нэвтрүүлэх гарын авлага” -д нэмж оруулахаар анхаарч, ямар үр дүн гарч буй талаар анкет судалгаа авч ажиллаж байна. Сумын хэмжээнд хамтран үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн санал бодол, төлөвлөгөө байвал төслөөс түүнийг нь дэмжиж ажиллах асуудлыг судалж байгаа юм байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-83,0%</p>
	<p>Үр дүн 5 Төслөөс туршлага хуримтлуулж, ойр орчмынхоо бүсэд танилцуулах</p>	<p>Орон нутагт танилцах аяллыг 2 удаа хийсэн нь бие биенээсээ суралцах чухал алхам болжээ. Төсөл хэрэгжиж буй сумдын иргэд, ААН-үүд төсөлд хамрагдсан ААН-дээс сурах, зэргэлдээ сумдад хосолсон аж ахуйг эрхлэх туршлага болж байна. Гэвч зарим аж ахуйн нэгжүүд 2008 оны эцэст тоног төхөөрөмж(Хонгор сумын мөнгөн ус, цианидтай холбоотой) авсан учир эцсийн үр дүн гарах харахан болоогүй байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдээс гарах олон талын санаа, туршлагыг дэлгэрүүлж, төслийн үлдсэн хугацаанд гарын авлагад оруулах хэрэгтэй. Дархан-Уул аймгийн Орхон сумын Засаг дарга 4 жилийн мөрийн хөтөлбөртөө Хосолсон фермерийн аж ахуйг эрхлэх сум болохоор зорилт тавиад ажиллаж байгаа нь Төслийн үр дүнг харуулах нэг үнэлгээ юм.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-86,0%</p>
11	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>МУЗГ-аас Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод тулгуурлан газар тариалан, МАА-н салбарыг дэмжиж байгаа, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн 2-р үе шат /2005-2012/ газар тариалангийн усжуулалтыг сайжруулах зэрэгт тулгуурлан хийгдсэн тул Төслийн зорилго нь Монгол Улсын Үндэсний Хөгжлийн Бодлоготой нийцэж байна. МАА-Газар тариалан хосолсон менежментийн ач холбогдлын талаар харилцагч талууд сайн ойлгож, аж ахуйн нэгжүүд болон ХААНТ-ын менежерүүд шинэ мэдлэг, аргачлал олж авсан болохоор Төслийн зорилгыг загвар аж ахуйн нэгжүүд загвар аж ахуйн нэгжүүд албан ёсоор сонгогдох үед Биелэгдэнэ гэж үзэж байна. Аж ахуйн нэгжүүдэд олгосон материал, тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад мониторинг хийж үзэхэд: Ашиглалт сайн. Зарим ААН-үүд хуримтлалын сангаас тоног төхөөрөмжийг засахад хэрэглэж байна. ХААНТ-д өгсөн тоног төхөөрөмжүүд зөв ашиглагдаж байна.</p> <p>Эерэг нөлөө: Аж ахуйн нэгжүүд нь загвар ААН болсноор 2 давуу талтай.</p>

		<p>а/ Материал, тоног төхөөрөмжтэй болсноор олон ААН ургацаа нэмэгдүүлэх боломжтой болсон.</p> <p>б/ Газар тариалан, МАА-н менежментийн мэдлэг, арга барил эзэмшсэнээр малын тоо толгой нэмэгдэж, улмаар тэдний орлого нэмэгдсэн.</p> <p>Сөрөг нөлөө: Төслийн эхэнд сонгогдож чадаагүй зарим ААН-үүд сонгогдсон нэгэндээ атаархдаг байсан. Энэ нь төслөөс материал, тоног төхөөрөмжөөр хангагдах, олон янзын сургалтад хамрагдах боломжтой байсантай холбоотой. Харин төслийн үйл ажиллагааг ойлгож эхэлснээр энэ байдал сайжирсан.</p>
11	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	<p>Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажиллаж байна. Төслийн хэрэгжилтэд 88.2% буюу “Хангалттай” гэсэн үнэлгээг өгч байна.</p>
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1. Энэхүү төслийн тогтвортой байдлыг хангахад Экстейншний чиглэлээр дараагийн төслийг хэрэгжүүлэх. 2. Сургалтуудыг үргэлжлүүлэх. 3. ХААНТ-ийг бэхжүүлэх.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА